

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван
хоёрдугаар хуралдааны тэмдэглэл /2015-01-13/**

Үндэсний зөвлөлийн арванхоёрдугаар хуралдаан 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 16 цаг 00 минутад Төрийн ордны “Нутгийн удирдлагын танхим”-д эхлэв.

Хуралдаанд Үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийг орлож Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд С.Баярцогт, Уул уурхайн сайд Р.Жигжидийг орлож тус яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Г.Отгочулуу, мэргэжилтэн Т.Зууннаст, Сангийн сайд Р.Эрдэнэбатыг орлож тус яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Г.Зулай, Монгол улсын Ерөнхий аудитор А.Зангадын орлож Гүйцэтгэлийн аудитын газрын дарга С.Төмөрхүү, Авилгатай тэмцэх газрын дарга Н.Ганболдыг орлож ахлах мэргэжилтэн Л.Батбаяр, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Эдийн засаг, маркетингийн хэлтсийн орлогч дарга Д.Галбаатар, Монголын нүүрс ассоциацийн ТУЗ-ын дарга Л.Даваацэдэв, Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Энхтуяа, Монголросцветмет ХХК-ийн ерөнхий захирлын зөвлөх М.Болдбаатар, Петровича дачин тамсаг ХХК-ны гүйцэтгэх захирал Б.Дэлгэрбаяр, Оюу толгой ХХК-ны ерөнхийлөгч Эндрью Вүдлэйг орлож ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Энержи ресурс ХХК-ын гүйцэтгэх захирал Г.Батцэнгэлийг орлож Зөвшөөрөл дотоод хяналт хариуцсан дэд ерөнхийлөгч Ч.Баяржаргал, Монголын алт МАК ХХК-ийн дэд ерөнхийлөгч Г.Цогтыг орлож А.Билэгсайхан, Монголын Алт үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч Т.Ганболдыг орлогч ажлын албаны дарга С.Бүрэнтогтох, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Ариун суварга хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч Н.Дорждарь, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Л.Долгормаа, Хонгор нутгийн дуудлага хөдөлгөөний тэргүүн Б.Батзоригийг орлож Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн ажлын албаны ажилтан З.Энэрэл, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа нар оролцов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн 30 гишүүдээс 25 гишүүд оролцож ирц 83 хувьтай байв.

Мөн хуралдаанд Ашигт малтмалын газрын даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяа, тасгийн дарга Б.Бямбадагва, Татварын ерөнхий газрын Эрдэс баялгийн татварын орлогын хэлтсийн ахлах байцаагч Ч.Батчимэг, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Улаанбаатар аудит корпораци ХХК-ны ерөнхий захирал Б.Осоргарав, аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, Адам Смит интернэйшнл байгууллагын менежер П.Оюунбилэг, Транспарэнси интернэйшнл байгууллагын Л.Төр-од, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон,

харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг, Мэдээлэл технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн арван хоёрдугаар хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд С.Баярцогт нээж үг хэлэв. Тэрээр нээлтийн үгэндээ:

“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг одоогийн байдлаар дэлхийн 48 улс орон хэрэгжүүлж байгаагаас манай улс энэ Санаачлагыг амжилттай хэрэгжүүлж байгаа орнуудын нэгд тооцогддог. Ингэж амжилттай хэрэгжүүлэхэд манай төр засаг, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, иргэний нийгэм идэвхтэй хамтран ажиллаж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Санаачлагыг хэрэгжүүлснээр итгэлцэл нэмэгдэж, хариуцлагатай байдал сайжирж байгааг цохон тэмдэглэе. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага нь талуудын эрх тэгш хамтын ажиллагаанд тулгуурладаг бөгөөд цаашид ч гэсэн үүнийг зарчим болгон нийгэм, эдийн бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллахыг оролцогч тал бүр ухамсарлан ойлгож, ач холбогдол өгөх ёстой гэж үзэж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Шилэн дансны тухай хууль батлагдаад энэ 2015 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Энэ нь ОУИТБС-ын чухал бүрэлдэхүүн хэсэг болсон Засгийн газар эрдэс баялгаас олсон орлогоо юунд зарцуулж буй олон нийтэд ил тодоор харуулах бололцоог олгож байгаа юм. Ингэснээр Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ букуу ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд шинэ дэвшил авчирна гэж бид үзэж байгаа. За дээр нь бид “Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төслийг санаачилан боловсруулж, 2015 ондоо УИХ-аар батлуулах боломжтой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ хууль, дээр нь нэмээд Шилэн дансны тухай хуулийг амжилттай хэрэгжүүлэх, улмаар иргэний нийгэм, олон улсын байгууллагууд хяналт тавьж оролцох бололцоо улам нээгдэнэ гэж үзэж байна. Сангийн яам, Монгол Банк, Статистикийн байгууллагын гэх мэт төрийн байгууллагуудын гаргадаг макро тоо мэдээлэл зөрүүтэй байгааг бид шүүмжилж ярьсан. Энэ Баасан гарагийн чуулганаар Ерөнхий сайд бүх макро тоо мэдээллүүдийг нэгтгэж танилцуулна, цаашид ч төрийн байгууллагуудын гаргадаг тоо мэдээг нэг болгож, ойлгомжтой байдлаар нийтэд хүргэдэг болно. Түүнчлэн аж ахуйн байгууллагуудад төрийн зүгээс хийж буй хяналт шалгалтыг Шилэн дансны тухай хуулийн нэг бүрдэл хэсэг болгоно. Тухайлбал мэргэжлийн хяналт, татвар, аудитын байгууллагын шалгалтыг ямар зорилгоор, хэн гэдэг даргын заавраар, ямар удирдамжтайгаар, хэдий хугацаанд, аль компани дээр хийсэн гэдгийг ил тод болгоно. Ингэснээр төрийн зүгээс үзүүлдэг олон шалгалтын дарамтыг байхгүй болгоно гэж харж байгаа. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд манай компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд хамтарж ажиллана гэдэгт найдаж байна. Татварын ерөнхий газар олборлолт бүхий аж ахуйн нэгжүүдээс авах ёстой татвар, төлбөрүүдийг бүрэн авч байгаа эсэх, Ашигт малтмал, Газрын тосны газрууд ногдуулах татвар төлбөрийн тооцоог зөв оновчтой хийж байгаа эсэхийг дотоод хяналтын журмаараа шалгаж, гарсан мэдээллийг Засгийн газрын 2014 оны Олборлох үйлдвэрлэлийн ил тод

байдлын мэдээнд оруулж, нийтэд мэдээлэх зүйтэй байна. Мөн Засгийн газры байгууллагууд, олборлох үйлдвэрлэлийн компаниудын хооронд байгуулс, гэрээнүүдийг ил тод болгоно. Хөрөнгө оруулалтын хуулийн дагуу зөвхөн хөрөн, оруулалтын гэрээнээс гадна компаниудад тогтвортой байдлын гэрчилгээ олгс эхэлнэ. Одоогийн байдлаар Хөрөнгө оруулалтын газарт арваад компаниу тогтвортой байдлын гэрчилгээ авах хүсэлтээ ирүүлээд байна. Бид ийм гэрчилгээ авсан компаниудыг нийтэд зарлаж, мэдээллийг та бүхэнд хүргүүлнэ. Засгийн газры зүгээс мэдээллийг иргэд, олон нийтийн байгууллагуудад ил тод хүргэх тал дээ, өөрсдөөсөө шалтгаалах бүх зүйлийг хийнэ. Энэ хуралдааны үеэр та бүхэн ОУИТБС Шилэн данс, бусад зүйлийн талаар оновчтой саналууд гарна гэдэгт итгэлтэй байна. За 2015 онд зохион байгуулах томоохон ажлуудыг дурьдвал бид ОУИТБС-ын Үндэсний чуулганыг талуудын оролцоотойгоор зохион байгуулна. Мөн ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооны дарга хатагтай Клэйр Шортыг 5 дугаар сард хүлээн авна. Оны эцсээр олон улсын баталгаажуулалт хийгдэх тул талууд бүгд идэвхтэй оролцох хэрэгтэй. Үр дүн нь Монгол улсынхаа нэр хүндийг өсгөх, ил тод байдлыг бэхжүүлэхэд маш чухал дэм болно. Иргэний нийгмийн байгууллагууд, талуудад хандаж хэлэхэд ОУИТБС-ын энэ 3 талын хамтын ажиллагаа нь Монгол улсын нэр хүндийг өндөрт өргөж байгаа шүү. Тухайн улсын нэр хүндийг олон улсад үнэлдэг “Doing business”, Транспарэнси интернэйшнл, Олон улсын авилгалын эсрэг конвенц гэх зэрэг олон хөтөлбөр, үйл ажиллагаа байдаг. Тэдгээр хөтөлбөрүүд нь тухайн орны зөвхөн Засгийн газрын макро датаг харахаас гадна иргэний нийгмийн өгч буй үнэлэмжээр зэрэглэлийг тогтоодог. Ийм учраас манай иргэний нийгмийн байгууллагуудын оролцох оролцоо нь зөвхөн шүүмжлэх талаас бус мөн эх оронч хандлагаар асуудалд ханддаг байгаасай гэж хүсэх байна. Тэр нь өөрөө манай улын зэрэглэл, нэр хүндийг өргөхөд их нөлөөлнө. Би хувьдаа манай энэ ОУИТБС-ын хүрээнд бий болсон 3 талын хамтын ажиллагаа маш их үр дүн өгч байгаа, үлгэр жишээ гэж боддог. Энэ сайн жишээгээ тэр Транспарэнси интернэйшл, Олон улсын авилгалын эсрэг конвенцын арга хэмжээ, Doing Business гэх зэрэг арга хэмжээн дээр бид нар ингэж хамтарч ажиллаж чаддаг шүү гэдэгээ бусдад сайн сурталчилмаар байна. Төгсгөлд нь хэлэхэд манай улсын нэр хүндийг унагааж буй бас нэгэн зүйл нь гадны орнууд манай орны талаар сөрөг мэдээлэл цацахад бид ямар нэгэн тайлбар хийхгүй байгаа явдал гэж байгаа юм. Энэ нь эргээд гарсан фактыг хүлээн зөвшөөрч байгаа мэтээр эсхүл гадаад орнуудын байр суурийг хүлээн авахгүй байгаа мэтээр харуулдаг юм байна. Тийм учраас шинэ Засгийн газар Монгол улстай холбоотой гадаад орны сонин, хэвлэлд гарч байгаа аливаа мэдээлэлд дор бүр нь хариу өгдөг болно, Засгийн газрын оролцоог илүү идэвхтэй байлгана” гэдгийг онцлоод хуралдаанд амжилт хүслээ.

Дараа нь Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Дэлгэрмаа хуралдааны хөтөлбөр, дотоод журмыг танилцуулж, гишүүдээс санал хурааж баталснаар хуралдаан эхлэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол улсын ОУИТБС-ын 2013 оны буюу наймдугаар тайлан

Б.Осоргарав: Үндэсний зөвлөлийн эрхэм гишүүд Та бүхний амар амгаланг айлтгая. Улаанбаатар аудит корпораци ХХК болон Их Британийн Харт Нойрс лтд компанитай хамтран Монголын ОУИТБС-ын 2013 оны буюу 8 дугаар тайланг аудитын 16 гишүүнтэй томоохон баг ажиллаж дуусгалаа. Нэгтгэлийн тайланг урьдчилсан байдлаар 2014 оны 10 сарын 10-ны өдрийн ажлын хэсгийн хурлаар танилцуулсан бөгөөд эцсийн хувилбарыг ном болгон хэвлэж тараасан учраас товчхон танилцуулга хийе. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Дэлгэрмаа: За баярлалаа, танилцуулгатай холбоотой асуулт байна уу?

П.Эрдэнэжаргал: Тайланг нэгтгэх ажлыг яагаад 7 сард эхэлсэн бэ? Гол шалтгаан нь юу байв?

Б.Осоргарав: Сонгон шалгаруулалтын үйл явц удааширсантай холбоотой гэж би хувьдаа ойлгож байгаа. Цолмон дарга дэлгэрэнгүй тайлбар өгөх болов уу.

Ш.Цолмон: Тендерийн шалгаруулалтын дүн 5 дугаар сард гарсан боловч, оролцогч 2 компани гомдол гаргасны улмаас хугацаа хойшилсон.

Х.Лхамаа: Зарим дүүргүүд нийгмийн даатгалтай холбоотой тодруулга, мэдээг өгөөгүй гэж байсан. Энэ яагаад өгөөгүй юм бол?

Б.Осоргарав: Нийгмийн даатгалын ерөнхий газрын харъяа 2 дүүргийн хэлтэс нь асуудалд тоймжиргүй хандаж, нэгтгэлийн ажлыг удаашруулж байсан. Энэ нь тухайн ажилтан, хувь хүнтэй л холбоотой асуудал, түүнээс бүх газрууд тийм байгаагүй.

Н.Баярсайхан: ОУИТБС-ын тайлан нь жилээс жилд сайжирч байгаа. Тайланд хандив, хөрөнгө оруулалт, бартерийн үйлчилгээг ялгаж харуулсан байна. Үүнийг яаж ялгасан бэ? Зарим төрийн байгууллагуудын мэдээлэл аудитлагдаагүй гэж байна. Тэгэхээр энэ тайлан хэр зэрэг үнэн байж чадах вэ? Тайланг үнэн гэдэгт яаж итгэх вэ?

Б.Мэндбаяр: Бид энэ жил ОУИТБС-ын шинэ стандартын дагуу тайлангаа гаргасан. Хөрөнгө оруулалтын шинжтэй зардлууд болон хандивыг өөрсдөө ангилж харуулсан.

Н.Эрдэнэцог: 2013 онд 10 компани ОУИТБС-ын тайлангаа аудит хийлгэсэн байсан. Бусад нь аудит хийлгээгүй байсан. Яагаад энэ ажил хийгдэхгүй байгаа талаар судлахад аудитын компани нь төлсөн татварыг баталгаажуулахад ажиллагаа орох учраас компаниас нэмэлт төлбөр шаардах зэрэг байдал үүсдэг, иймээс уг аудит хийгддэггүй байна. Бид шаардлагын дагуу зөрүүг тогтоож, зөрүүний шалтгааныг тогтоох үүрэгтэй.

П.Эрдэнэжаргал: Аудитын явцад шинэ стандартын дагуу компаниудаас газрын тосны болон Засгийн газартай байгуулсан гэрээг авсан байна.Тэгэхээр энэ гэрээнүүд яаж ил тод болох вэ?

Б.Мэндбаяр: Бид гэрээний судалгаа авахаар байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн боловч газрын тосны компаниуд тэр олон гэрээг хуулбарлах боломжгүй гэсэн хариу өгсөн. Зарим компаниуд гэрээний хуулбарыг явуулсан. Харин орон нутгийн засаг захиргаанаас гэрээг явуулахыг хүссэн боловч 2-3 аймаг л явуулсан. Иймд зөвхөн гэрээний дүгнэлтийг авч судалгаагаа хийсэн. Үүнд сумын захиргаатай хийсэн болон аймгийн захиргаатай хийсэн гэрээ, гэрээг дүгнэсэн, дүгнээгүй гэсэн байдлаар судалгаа авсан. Бүх аймгуудаас судалгааг гарын үсэг, тамга тэмдэгтэй хүлээн авсан. Шаардлагын дагуу гэрээний талаарх мэдээллийг тайланд дэлгэрэнгүй хавсралтаар оруулсан.

Н.Эрдэнэцог: Хэрвээ шаардвал бүх гэрээний хуулбарыг авах боломжтой.

Б.Осоргарав: Хүлээн авсан гэрээний хуулбар манай ажлын баримт болж үлдсэн. Тэдгээрийг хүлээлгэн өгсөн байгаа. Ер нь гэрээний хуулбарыг авахад маш хүндрэлтэй юм байна лээ.

Ш.Цолмон: Ажлын албанд албан ёсоор хүлээлгэж өгөөгүй байгаа шүү. Дараа нь жагсаалтаар хүлээлгэж өгөх хэрэгтэй.

Г.Уранцоож: Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тайланг харахад мянган төгрөгөөр гэсэн мөртлөө зарим нь маш бага тоо байх юм. Энэ яагаад ийм бага байна вэ? Байгаль хамгаалах зардал, нөхөн сэргээх зардал 2 чинь тус тусдаа юу эсвэл нэг зардал байна уу

Н.Алгаа: Хуулиар бол хайгуулын ажлын 1 жилийн зардлыг орон нутагт төвлөрүүлдэг. Иймээс хайгуулын компаниуд хайгуул хийгээгүй бол ямар нэг төлбөр төлөхгүй, барьцааны механизм нь 1 жилийн зардлын гэсэн байдаг болохоор компаниуд жилийн зардлаа хамгийн багаар төлөвлөөд, багаар төлбөрөө төлж байгаа нь энэхүү хайгуулын ажлын зардалд бага мөнгө төлөх шалтгаан болдог. Харин ашиглалтынх арай бодитой тоо гарах байх.

Л.Долгормаа: Байгаль хамгаалах зардлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоох ёстой. Өөрөөр хэлбэл тухайн компаниас байгаль орчинд ямар нөлөөлөл гарч байгааг тооцоолоод гаргаж өгдөг зардал. 5 жилээр тооцоод эхний нэг жилд ямар хэмжээний зардал гарахаар байна, түүний 50 хувийг уг дансанд байршуулах ёстой. Үүнийг эрдэмтдийн судалгаа шинжилгээгээр нарийн тогтоосон зардал байх ёстой боловч сүүлийн үед үнэлгээ хийдэг компаниуд хуйвалдаж, үнэлгээг худлаа хийж байгаагаас компанийн нэр хүнд унаж, байгаль хамгаалах зардал ч бага гарч байна. Яг номоороо хийдэг бол хайгуулын ажлын зардал 60 сая төгрөг гарна гэж тооцоолвол түүний 30 сая төгрөгийг байгаль хамгаалах зардалд төлөх ёстой. Тэгэхээр бид цаашид үүнийг анхаарч, тал талдаа хяналттай байх хэрэгтэй гэж бодож байна.

Б.Дэлгэрмаа: Ажил хэрэгч санал гарч байна.

Г.Чагнаадорж: Би энэ хуралд 7, 8 жил оролцож байна. Санаачилгын талуудын оролцоо улам сайжирч байгаа гэж бодож байна. Энд хариуцлагын ярьмаар байна. Урьд нь Сангийн яам, Ашигт малтмалын газар, байгууллагуудыг шүүмжилдэг байсан бол эдгээр байгууллагууд одоо хам ажиллаж байна. Гэтэл Гаалийн ерөнхий газар гэж дийлддэггүй том байгууллага Тэр байгууллагыг Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагад оруулж болдоггүй Компаниудын оролцоо сайжирч, ухамсарлаад байхад төрийн байгууллага хариуцлагагүй хэвээр байх юм. Мөн тэр Үндэсний аудит газрын болон Улаа аудитын гаргасан дүн нь зөрүүтэй байгаа нь ямар учиртай вэ?

Б.Дэлгэрмаа: Агентлагуудыг Үндэсний зөвлөлийн хуралдаанд урьдаг. Ё жишээ нь Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар байна. Гэсэн хэдий ч Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд Сангийн сайд байдаг харъяа агентлаг нь ирэхгүй байх, тэгж үл тоомсорлож болохгүй л дээ. За ю Үндэсний аудитын газраас ирсэн хүний тайлбарыг сонсоё.

С.Төмөрхүү: Би тэр материалыг хараагүй учраас чухам яг ямар зөрүүг асу тодруулах шаардлагатай байна. Үндэсний аудитын газар төрийн өмчит аж нэгжүүдийн, төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланг баталгаажуулдаг. Түү хувийн хэвшлийн компаниудын тайланд аудит хийдэггүй.

Н.Эрдэнэцог: Манай гаргасан 2013 оны тайланд, улсын төсөвт уул уурх салбараас орсон орлого нь 1 их наяд 565 тэрбум төгрөг гэж тусгасан. Энэ нь тус зөвшөөрөл эзэмшиж байгаа компаниудын 96 хувь юм. Харин Үндэсний аудит газраас 2013 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн тайланд уул уурхайн компаниуда орсон орлогын дүн нь өөр тоо байгаа юм. Үүний зөрүүг асуусан байх аа.

С.Төмөрхүү: Үүнийг эргэж нягталж үзье. 250 компанийн тоо юм уу, манс тайланд улсын хэмжээний бүх уул уурхай компаниудаас төлсөн татвар орсон байгаа аудитад ороогүй, баталгаажаагүй гэх зэрэг янз бүрийн үзүүлэлтээс болоод зөрүүтэ байх магадлалтай.

Б.Дэлгэрмаа: Эхлээд ялгаж салгах хэрэгтэй. Шууд зөрүү гарч байна гэж хэлж болохгүй байх л даа. За өөр асуулт байна уу?

Н.Дорждарь: Би түрүү жил асуусан асуултаа аудитын байгууллагаас асууя. Компаниуд 1,5 их наяд төгрөгийн татвар төлсөн байна. Энэ дотор хэд хэдэн том татварууд байгаа. Тухайлбал, компанийн ашгийн татвар, нэмүү өртөгийн татвар. Тэгэхээр энэ компаниуд нь эдгээр татвараа зөвхөн уул уурхайн үйл ажиллагаанаасаа төлсөн гэж та баталгаажуулж чадах уу, өөрөөр хэлбэл тэр 1,565 тэрбум төгрөг нь зөвхөн уул уурхайн үйл ажиллагаанаас төлсөн татвар уу эсхүл өөр үйлдвэр, үйлчилгээнээс төлсөн татвар нь хамт орсон байна уу. Хэрвээ үүнийг ялгаж чадахгүй

байгаа бол бид цаашид яах ёстой вэ? Та мэргэжлийн хүний хувьд ямар з байна вэ?

Н.Эрдэнэцог: Бид 250 компанийг хэрхэн яаж сонгож авсан тала албанаас тайлбар авч, өөрсдийнх нь хийсэн материал дээр судалгаа хийсэн энэ сонголт хийх зарчмыг сайжруулах шаардлагатай гэсэн зөвлөмж өгсө Гэхдээ энэ жил нэгтгэлд хамрагдсан 250 компаниуд яг л үндсэн үйл ажиллаг уурхайн компаниуд байсан. 40 сая төгрөгөөс дээш татвартай боловч 6 компаниудыг хассан байх жишээтэй байсан. Энэ талаар Цолмон гуай илүү өгөх байх аа.

Н.Дорждарь: Цолмон гуай та ямар шалгуураар тэр компаниудыг сонгоч олон бизнес эрхэлдэгийг нь яаж мэдэв ээ?

Ш.Цолмон: Энэ талаар манай ажлын албаны мэргэжилтэн Дэлгэрмаа хари

Ажлын албаны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа: Түрүү жилийн аудитын байгуул. өгсөн зөвлөмжийн дагуу бид энэ жилийн аудитын нэгтгэлд орох компани сонгохдоо их няхуур хандсан. Ажлын албанаас эхлээд 7-8 шалгуур үзүүлэлт, ц гаргаж, тэр аргачлалаар 250 компанийг сонгож, Ажлын хэсгийн гишүүд рүү цахим явуулж, санал авсан. Ингэхэд Монголын Уул уурхайн үндэсний ассоциац, Татва ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Оюу толгой ХХК гэсэн 4 байгууллагаа санал ирүүлсэн. Тэдгээр саналыг тусгаад сонгосон. Тухайлбал: Тайлан гарга давхардаагүй тоогоор 1670 компаниас нэгдүгээрт, 40 сая төгрөгөөс дээш гэ шалгуураар шүүхэд 578 компани үлдсэн, дараа нь эдгээр компаниудийг Аши малтмалын газрын тусгай зөвшөөрлийн мэдээг ашиглалтын, түгээмэл тархацтай аши малтмалын, газрын тосны, хайгуулын гэж ангилсан. Ингээд 250 компанид 57 компаниас түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад ашиглалтын лицензтэй олборлолт хийсэн 120 компанийг жагсаалтад оруулсан. Үүнийг бид ОУИТБС-ын маягт буюу Ашигт малтмалын газрын Уулын ажлын тайлан, төлөвлөгөөтэй нь харьцуулж тулгаж гаргасан, дараа нь газрын тосны, ураны 10 компаниуг оруулсан, ингээд үлдэх 120 компанийг ач холбогдолын эрэмбээр нь буюу хамгийн их татвар, төлбөр төлсөн үйл ажиллагаа явуулаагүй боловч, ашиглалтын лицензтэй 161-ээс эхний 80 компанийг, хайгуулын лицензтэй 164-өөс эхний 40 компанийг оруулж ингээд 250 компанийг сонгосон. Ингэхдээ бид Татварын ерөнхий газраас үндсэн үйл ажиллагаа нь уул уурхай эсэхийг лавлаж, жагсаалтаас хасах зарчмаар ажилласан. Энэ бүх үйл явцыг бид тухай бүр Ажлын хэсгийн гишүүд рүү цахим шуудан явуулж, санал авч байсан.

Н.Дорждарь: Тайланд миний мэддэг жонш олборлодог компани орсон байна. Энэ компани том худалдааны төвтэй, жижиг хэдэн ресторантай. Тэгээд энэ компани нэг л тайлан гаргадаг. Үүнийг яаж салгаж үзсэн бэ? Уул уурхайн салбарын орлогыг тусад нь яаж тусгах талаар татварын албаныхан хариу өгөх үү?

Ч.Батчимэг: Татварын алба орлогын албан татварыг ялгаж авдаггүй, энэ нь салгах боломжгүй. Харин орлогыг үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого гэдгээр нь салгаж авдаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулинд ч ийм байгаа.

Н.Дорждарь: Энэ талаар олон удаа ярьж байсан, үүн дээр ямар нэг санал боловсруулж, зөвлөмж гаргамаар байна. Тухайлбал Алгаа дарга, Уул уурхайн яам оролцоод судламаар байгаа юм л даа. Ашиглалтын үйл ажиллагаагаа тухайн компани тусад нь компани байгуулж явуулах боломж байх уу? эсхүл энэ нь компаниудад хэт хатууддаг юм болов уу хэлж мэдэхгүй байна л даа. Эсхүл уул уурхайн орлогыг тусад нь бүртгэх бүртгэлийн аргаар ч юмуу. Энэ бол тийм амархан асуудал биш гэдгийг ойлгож байгаа.

Б.Дэлгэрмаа: Тэгвэл эхний удаад агентлагуудаас, яамдаас, мэргэжлийн холбоодоос, иргэний нийгмийн байгууллагуудаас оролцуулаад дээрээс нь та өөрөө ороод ажлын хэсэг байгуулаад эхний ээлжинд судалгааны түвшинд боловсруулалт хиймээр байна. Энэ асуудлыг ингэж шийдье. За өөр асуулт байна уу?

С.Энхтуяа: Уул уурхайн компаниуд жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулдаг, тэгээд үүндээ байгаль хамгаалах зардлаа оруулдаг. Тэр зардлынхаа 50 хувийг байгаль хамгаалах дансанд байршуулдаг. Өмнө жил нь төлөвлөгөөг биелүүлсэн гэсэн үнэлгээ авсан компаниуд барьцаагаа буцаагаад авдаг, зарим нь барьцаагаа дараа жилдээ шилжүүлээд явдаг. Үүнээс үүдээд зөрүү гараад байгаа байх. Нөгөөтэйгүүр уул уурхайн бизнес хүнд байдалтай байгаа учраас тэр барьцаа хөрөнгө багасаад байгаа байх гэж бодож байна.

Г.Уранцоож: Байгаль хамгаалах зардал нь зөвхөн энэ жил ийм бага байгаа биш л дээ. Ер нь хэдэн жилийн өмнөөс бага байгаад байгаа юм. Тиймээс энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байгаа юм. Бодитой болгомоор юм шиг, компаниуд ч гэсэн тэр их хөрөнгөө дэмий барьцаалуулаад байхгүйгээр, нөгөө талаас тэр байгаль орчны нөхөн сэргээлт нь номоороо л хийгдэж байх ёстой. Иймээс байгаль хамгаалах зардлын асуудал дээр Үндэсний зөвлөл анхаарч ажиллах хэрэгтэй байх. Иймд ажлын хэсэг байгуулан тодорхой санал боловсруулах нь зүйтэй гэсэн саналтай байна.

С.Энхтуяа: Яг үнэн, би түрүүнд яг тийм санал гаргах гэж байсан юм. Уул уурхайн компаниудын хувьд энэ байгаль орчны барьцаа төлбөр үнэхээр дарамт болдог. Байгаль орчноо бас сайн нөхөн сэргээмээр байдаг, жишээлбэл 200 сая төгрөгийн ажил төлөвлөлөө гэхэд 100 сая төгрөг барьцаалуулах хэрэгтэй болдог, гэтэл бид өнөөдөр тэр мөнгөөрөө бензинээ хийсэн нь илүү ач холбогдолтой, тэгээд компаниуд багаар төлөвлөж, бага мөнгө байршуулдаг. Тиймээс уул уурхайн томоохон компаниудыг тэр барьцаа төлбөрөөс чөлөөлөх ч юмуу өөр системд шилжихгүй бол одоогийн энэ систем үр дүнгүй байгаа.

Б.Дэлгэрмаа: За сайн сайн саналууд гарч байна. Ажлын хэсгүүд тодорхой болж байна. 2015 онд бид нилээд ажил хэрэгч байх нь харагдаж байна. За одоо 1 асуулт, тэгээд саналдаа орье.

Д.Эрдэнэчимэг: 2013 оны тайланд ашиг хүртэгч, хувьцаа эзэмшигдийн талаарх мэдээлэл орсон байна. Энэ нь хэр баталгаатай вэ?

Н.Эрдэнэцог: Компаниудаас хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл ирүүлэхийг хүсэж, мэдээлэл авсан. Компаниуд боломжийн байдлаар хариу өгсөн, өгсөн мэдээллийг л хавсаргасан байгаа.

Б.Дэлгэрмаа: За асуултууд дууслаа, санал хэлэх хүн байна уу?

Н.Алгаа: Энэ жилийн тайланд шинэ стандартын дагуу нилээд мэдээлэл орсон байна, тийм учраас ахиц дэвшил гарсан байна гэж үзэж байна. Аудитын ажил хийсэн байгууллагадаа талархал илэрхийлье. Тайланд дунд болон муу үнэлгээ авсан компаниудыг зорилтот бүлэг болгон сургалт явуулах хэрэгтэй байна. Гэрээг ил тод болгохоосоо илүү хэдэн гэрээ байгаа юм, ямар үр ашигтай байна гэдэг талаас нь судалгаатай болж байж цаашид асуудлыг ярих нь зүйтэй. Бусад уул уурхайн хөгжиж байгаа орнуудад нягтлан бодох бүртгэлд нь уул уурхайн орлого нь тусдаа явдаг. Тэгэхээр Сангийн яам, Татварын ерөнхий газар уул уурхайн хэлтэстэй болсон бол тэр уул уурхайн бүртгэлийг илүү сайжруулах, зардлыг нь хашдаг гэх зэрэг байдлаар тэр бүртгэл дээрээ шийдэхгүй бол бид үүнийг мянга яриад шийдвэрлэх боломжгүй. Энэ ажил нь төвөгтэй боловч хийх ёстой ажлын нэгж гэж үзэж байна. За байгаль орчны асуудлын тухайд би бол байгаль орчныг зардал талаас нь бус байгаль орчинд мониторинг хийдэг тогтолцоон дээр санаа зовоод байгаа юм. Хууль, журам их байгаа ч хэрэгжихгүй байна. Энд хөндлөнгийн, мэргэжлийн байгууллагуудыг Засгийн газар итгэмжлэл олгоод тэр 700 байгаль орчны иргэний нийгмийн байгууллагуудыг шалгаруулаад, чадавхийг нь бэхжүүлээд, тэр байгаль орчинд үнэлгээ хийдэг компаниуд нэг их мөнгө аваад алга болчихдог, хэрэв үнэлгээ хийсэн бол тэр ажлын хөлсөндөө оруулж тооцоод 3 жил мониторинг хийдэг ч байдаг юмуу ингэж өөр байдлаар хандахгүй бол болохгүй нь ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Галбаатар: 2 санал хэлье. Би нэг 2, 3 удаа энэ тайланг сонслоо. Ерөнхийдөө бол сүүлийн стандартын хүрээнд тайлан хангалттай сайн болсон байна гэж ойлгож байна. Стандарт нь сайжирч байгаа учраас тайлан сайн болсон байна. Гэхдээ 2 зүйлийг харж үзээсэй гэж бодож байна. Нэгдүгээрт, энэ компанийн засаглалийн асуудлыг тайландаа та бүхэн хамруулж байгаагчээ. Эрдэнэт үйлдвэрийн удирдах зөвлөл өнөөдрийг хүртэл Эрдэнэт үйлдвэрийн төлөвлөгөөг батлаагүй байна. Энэ асуудал тайланд тусгагдах хэрэгтэй гэж үзэж байна. Хоёрдугаарт, Эрдэнэт үйлдвэрийн жишгийг олон жил ярьж байна. Сая гарлаа улсын төсөвт 2012 онд 520 тэрбум төгрөг, 2013 онд 508 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Гэтэл Оюутолгой ХХК 2 дахин бага татвар төлж байна. Ер нь ямар учраас ОУИТБС-ыг хэрэгжүүлсэн эхэлсэн бэ гэхээр энэ дэлхий дээр байгаа хэзээ ч нөхөгддөггүй байгалийн баялгийг яаж тулхтай ашиглах ёстой юм бэ? Би тогтвортой гэж хэлээгүй шүү, "тулхтай" гэж хэлж байна. Энэ асуудлын хүрээнд

л санаачилга бий болсон гэж ойлгож байгаа. Яаж хариуцлагатай байх ёстой юм, яаж өндөр орлоготой байх ёстой юм, яаж үр ашигтай байх юм? Эрдэнэт үйлдвэр өнөөдөр борлуулалтын орлогын 30-50 хувийг татварын хэлбэрээр төсөвт төлдөг, ашгийн цэвэр үлдэгдлийн 75 хувийг ноогдол ашиг хэлбэрээр өгдөг. Энэ учир шалтгааныг тайланд тусгах ёстой гэж үзэж байна. 2014, 2015 онд Оюу толгой бас бага өгнө. 2015 онд Эрдэнэт үйлдвэр 119,000 тн цэвэр зэс үйлдвэрлэнэ, Оюу толгой 197,000 тн цэвэр зэс агуулсан зэсийн баяжмал үйлдвэрлэнэ, Оюу толгой 61 сая ам.долларын роялти төлнө, Эрдэнэт үйлдвэр 160 сая ам.долларын роялти төлнө. Ийм байж болох уу? Үүний учир шалтгааныг гаргаж ирэх ёстой. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр хууль эрх зүйн орчинд нэг татварын нөхцөлтэй байх ёстой. Үндсэн хуулиндаа ч ингэж заасан. Тогтвортой, тогтвортой гэхихээд Оюу толгойгоос 5%-ийн роялти, Эрдэнэт үйлдвэрээс өсөн нэмэгдэх байдлаар өнөөдрийн байдлаар 17-18%-ийн роялти авч байна. Энэ зүйлүүд дээр аудит хийх хэрэгцээтэй.

Б.Бямбадагва: 2013 оны тайлан гаргахад шинэ стандартын дагуу ихээхэн мэдээлэл шаардсан учраас 10 гаруй хүнийг үндсэн ажлаас нь чөлөөлж хийлгэсэн. Маш олон төрлийн судалгааны материалуудыг бэлтгэж гаргахад манай хүмүүс сар шахуу ажилласан. Энэ нь цаашдаа ийм байвал төрийн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь нөлөөлж болзошгүй юм. Иймаас ажлын алба, ажлын хэсэг судалгааны маягт, тайлангийн шаардлагуудыг нягтлан харах хэрэгтэй болов уу. Хамрах хүрээ цар хүрээ нь нэмэгдэхийн хэрээр үр дүнгүй ажлууд хийгдэж байна.

П.Эрдэнэжаргал: Энэ бол зайлшгүй гарах ёстой ажил юм. Харин яаж уялдуулах талаар ажиллах хэрэгтэй байна. Тайланг харахад асар их судалгаа хийсэн байна, харин үүнийгээ яаж хүргэх вэ гэдэг талаар ажиллах хэрэгтэй байна.

Ч.Баяржаргал: Манай компани дээр шалгалт тасардаггүй. Олон төрлийн тайланг гаргадаг, энэ нь хамгийн сүүлд санхүүгээр баталгааждаг. Иймээс мэдээллийг хамгийн бага зардлаар богино хугацаанд үр дүнтэй хүргэх талаар ажиллах хэрэгтэй.

Л.Долгормаа: Жил бүр тайлан гаргаж байна, үүнийгээ хэрэгтэй хүмүүст нь хүргэх хэрэгтэй байна. Энэхүү тайлан, мэдээллээ хүмүүст хүргэх талаар сайн ажиллах хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: Энэ жилийн тайланг ИНБ-ууд авч ашиглахад хялбар, сайн болсон гэж үзэж байна. Жишээлбэл хандивыг сумаар нь, зориулалтаар нь харж болж байна. Тайланд хойрго хандсан төрийн байгууллагуудад ямар хариуцлага тооцох юм? Зөрүү гарсан байна, зөрүү гаргасан тэр Монголболгаргео гэдэг компанид ямар хариуцлага тооцох юм, Тэгэхээр бид хариуцлагыг ярихгүйгээр жил бүр өчнөөн зардал гаргаад, ингэж хэлэлцсэний үр дүн байхгүй болно. Бид тайлангийн үр дүнгээс хариуцлага тооцдог болмоор байна. Энэ талаар хуулинд ч тусгагдсан байгаа. Хоёрдугаарт, тайланг УИХ-ын гишүүдэд, Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодод хүргүүлж, танилцуулах хэрэгтэй байна. Урьд урьдын тайлангууд огт хүрээгүй. Тиймээс байнгын хороо дээр манай хуулийг хэлэлцэж байхад зарим гишүүд ямар ч ойлголтгүй байсан. За дараа нь тайланг иргэд, олон нийтэд хүргэх хэрэгтэй

байна. Энэ ажлуудыг шийдвэрийн төсөлдөө тусгах хэрэгтэй. Баярцогт сайд хэллээ хувийн хэвшилд очиж буй шалгалтуудыг шилэн болгоно гэж байна. Энэ бол мэдээж чухал, нэгэнт тэгж болж байгаа бол гэрээг шилэн болгох санал байна. Хандив, хөрөнгө оруулалтыг салгаж ойлгох хэрэгтэй байна. Үүний тулд нэгдсэн ойлголттой болохын тулд хэлэлцүүлэг хийх хэрэгтэй. Энэ талаар ТАН эвслийн 2014 оын эхээр хийсэн олон талт хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийн нэг байгаа. Дээрх саналуудыг хурлын шийдвэрт тусгаж ажиллахыг хүсэж байна.

Г.Уранцоож: Бид ТАН эвслийн хүрээнд эхний 6 жилийн тайланд өгсөн зөвлөмжүүд дээр мониторинг хийсэн. Ихэнх зөвлөмж нь хэрэгжээгүй мартагдсан байдаг. Бид үүнийг шийдвэрлэх талаар үргэлжлүүлэн ажиллаж байгаа. 2015 оны ажлын төлөвлөгөөнд аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ажлын төлөвлөгөө боловсруулж, түүний мөрөөр ажиллах нь зүйтэй, энэ талаар төлөвлөгөөнд оруулах саналтай байна. Баярлалаа.

Л.Даваацэдэв: Одоо өргөн баригдсан Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хууль нь олон хуульчилсан үйл ажиллагаан дээр орж ирж байгаа хууль юм. Өнөөдөр гараад байгаа энэ зөрчлүүд нь магадгүй хууль гараагүй учраас үүсэж байж болох юм. Тиймээс хуулийн төслийг хэлэлцэхээс өмнө Засгийн газар ажлын хэсэг гаргаж тэр олон гаргадаг мэдээ, тайлангуудаа хэрхэн уялдуулах талаар эргэж харах ёстой юм шиг харагдаад байна.

Б.Дэлгэрмаа: За баярлалаа. Ажил хэрэгч саналууд гарлаа. Шийдвэрийн төслийг та бүхэнд тараасан ч саяны гишүүдийн саналуудыг тусгаад шийдвэрийн төслөө нилээд өөрчилмөөр байна. Галбаатар гуай түрүүнд их чухал санал хэллээ. Монголын уул уурхай нүүр царай болсон 10 том компаниудын асуудлыг хэрхэн авч үзэх юм, за тэр хэвлэл, мэдээллийн ажил байна, байгаль орчны зардлын талаар, нөхөн сэргээн ажлын мониторингийн санал гарлаа гэх мэт. Юуны түрүүнд бид 1 дүгээр улиралдаа багтаад яаралтай ажлын хэсгүүдээ байгуулья.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Их Британийн Харт Нойрс лтд, Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан аудитын консерцумын боловсруулсан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны буюу наймдугаар нэгтгэл тайланг дэмжиж батлав.

2. Энэхүү тайланг олон нийтэд хүргэх, зорилтот бүлгүүдэд сурталчилах хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулахаар тогтов. Үүнд:

2.1 Тайланг ОУИТБС-ын Олон улсын удирдах хороонд 2015 оны 1 дүгээр сарын 20-ны дотор илгээхийг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

2.2 Тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар нийтэд мэдээлэх хэвлэлийн бага хурлыг 1 дүгээр сард багтаан зохион байгуулахыг ОУИТБС-ын ажлын алба, Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.

2.3 Тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд чуулган завсарлахаас өмнө танилцуулахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх (Б.Дэлгэрмаа), Уул уурхайн яам (Р.Жигжид)-д даалгав.

2.4 Эх тайлан болон тайлангийн хураангуй хувилбарыг оролцогч талуудын болон ОУИТБС-ын ажлын албаны цахим хуудсанд байрлуулж, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.

2.5 Тайлангаас олж илрүүлсэн зүйлс, онцлох мэдээлэлтэй холбоотойгоор талуудын байр суурийг илэрхийлэх хэвлэлийн бага хурлыг 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Нээлттэй нийгэм форум (П.Эрдэнэжаргал)-д, Монголын Үндэсний уул уурхайн ассоциацийн ерөнхийлөгч (Н.Алгаа)-д, салбарын үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлэх зорилго бүхий “Ил тод уул уурхай” сэтгүүлчидтэй уулзах уулзалтын үеэр ОУИТБС-ын талаар мэдээлж ажиллахыг Уул уурхайн яам (Р.Жигжид)-д, даалгав.

2.6 Тайлангаас зорилтот бүлгүүдэд зориулсан мэдээлэл боловсруулж, 2015 оны ажлын төлөвлөгөөнд заасны дагуу тогтмол сурталчилахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

3. Уул уурхайн салбарын орлогыг тусад нь бүртгэх асуудлаар, байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа төлбөр, мониторинг хийх асуудлаар, аудитын нэгтгэлийн үеэр аудитын байгууллагад гаргаж өгөх шаардлагатай мэдээллийн жагсаалт боловсруулж, түүнийг нэг стандарт, маягтад оруулах асуудлаар, эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээ, түүний ач холбогдлыг судлах асуудлаар, уул уурхайн салбарын эхний топ 10 аж ахуйн нэгжүүдэд хууль жигд үйлчлэх асуудлаар тус тус төрөлжсөн 5 ажлыг хэсгийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүд, холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулан 1 дүгээр улиралд багтаан байгуулах, ажлын удирдамж боловсруулж, чиглэл өгч ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх (Б.Дэлгэрмаа)-д даалгав.

4. Тайлангаар дунд болон муу үнэлгээ авсан төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдээс тайлбар авч, удирдах дээд байгууллагад хариуцлага тооцох тухай албан тоот илгээх, зохих сургалт зохион байгуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд үүрэг болгов.

5. Жил бүр Засгийн газрын гаргадаг ОУИТБС-ын тайланг Үндэсний аудитын газраар баталгаажуулах, шаардлагатай тул холбогдох журам боловсруулж, мөрдүүлэхийг Сангийн яам (Ж.Эрдэнэбат), Үндэсний аудитын газар (А.Зангад)-т зөвлөмж болгов.

6. Нэгтгэлийн тайлангаар ил тод болсон олборлох үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигчийн мэдээллийг нэгдсэн сан болгож, цахим хуудастаа байрлуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав

II, III ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2014 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2015 оны төлөвлөгөөний тухай

П.Эрдэнэжаргал: Журмын санал байна. Бид 2014 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг уншсан болохоор ярих хэрэг байна уу? Эсвэл Цолмон гуай та 5 минутыг 2 минут болгоод онцолж хэлэх зүйл байна уу?

Г.Уранцоож: Би Сэлэнгэ явах учраас одоо ингээд явчих уу? Чөлөө хүсэх гэсэн юм.

Д.Галбаатар: Би бас явж байж болох уу? 2015 оны төлөвлөгөөг дэмжиж байгаа. Ингээд холын хүмүүс нь явж байвал яасан юм бэ?

Б.Дэлгэрмаа: За Уранцоож, Галбаатар нар саналаа бүрэн гүйцэд хэлсэн учраас хол замд явах хүмүүсээ Үндэсний зөвлөлийн хуралдаанаас урьдчилж чөлөө олгоё. Сайн яваарай.

Ш.Цолмон: За би 2013 оны тайлантай холбоотой онцлох зүйлсийг товчхон мэдээлье. ОУИТБС-ыг дэлхийн 48 орон хэрэгжүүлдэгээс одоогийн байдлаар 2013 оны тайлангаа гаргаад байгаа гуравхан улс байна. Сан-Томе Принсипи, Казакстан ингээд манай улс. Тэгэхээр манай улс тэргүүлэх байр сууриа хадгалсан хэвээр байна. Хоёрдугаарт 2014 онд бид нилээд ажил хийхээр төлөвлөсөн боловч Дэлхийн банкны санхүүжилт тасарсны улмаас зарим ажлууд гацсан болно. Онцлох томоохон ажил бол бид Эрдэс баялгийн салбарын тухай хуулийн төслөө Засгийн газрын хуралдаанаар батлуулж, УИХ-д өргөн барьж чадсан. Энэхүү үйл ажиллагааг манай Уул уурхайн яам мөн техник туслалцаа үзүүлсэн Европын сэргээн босголт хөгжлийн банк, Адам смит интернэйшнл байгууллага хариуцан маш идэвх, зүтгэлтэй сайн ажилласаныг онцлох нь зүйтэй. Мөн 9-11 сард сумын түвшинд санаачилгыг хэрэгжүүлэх, олон нийтэд мэдээлэл түгээх, чадавх бэхжүүлэх зорилт тавьж 9 суманд өдөрлөг зохион байгууллаа. Үр дүнд нь 4 суманд салбар зөвлөл байгуулагдсан. Орон нутагт ажиллахад ТЕГ, АМГ, МУУҮА, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, ТАН эвсэл гэх зэрэг оролцогч талууд томилолтоор хамт явж, асар их хувь нэмэр оруулсан. Цаашид бид энэ ажлыг 2015 онд үргэлжлүүлнэ ээ. Дархан-Уул, Орхон аймаг дэд зөвлөлөө байгуулаагүй. Удирдлагуудтай уулзаж, зөвлөмж өгч, холбогдох бүх бичиг баримтуудыг хүргүүлсэн боловч байгуулахгүй хэвээр байна. Иймд Үндэсний зөвлөлөөс эдгээр аймгуудын дарга нарт албан бичиг хүргүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Бас нэг онцлох гол ажил бол хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны ажлыг өнгөрсөн онд нилээд хийлээ. Тухайлбал 2011-2013 оны тайлангийн мэдээг суманд зориулж тухайн сумын мэдээллийг нь боловсруулан 2700 ширхэгийг хэвлүүлж, өдөрлөг зохион байгуулсан сумдад хүргүүлсэн. Эцэст нь онцолж хэлэхэд ОУИТБС-ын цахим тайлангийн систем боловсруулж ашиглалтанд орууллаа. 2014 оны тайлангаа компаниуд болон Засгийн газар цахимаар тушаана. Ингээд 2014 онд бидэнтэй нягт хамтран ажилласан Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүддээ Ажлын албаны өмнөөс талархал илэрхийлье. Энэ эрчээ алдалгүй 2015 онд дахин нягт хамтран ажиллана гэдэгт итгэж байна. Бидэнд

Дэлхийн банкны санхүүжилтээр ажиллах 1 жил үлдсэн, 2015 онд санхүүжилт дуусна. Энэ санхүүжилтын үр ашгийг гаргах хэмжээнд, 2015 оны баталгаажуултанд амжилттай орох хэмжээнд бид үр бүтээлтэй хамтран ажиллана гэдэгт найдаж байна. Баярлалаа.

П.Эрдэнэжаргал: 2 санал байна. Тайлангийн нэгтгэлийг хийдэг аудитын компанийг 2 жилээр сонгон шалгаруулбал яасан юм бэ? Үндэсний зөвлөлийн гишүүд энэ асуудлыг авч үзээд, шийдвэр гаргачихбал бид цаг алдахгүй байх боломжтой болно. Тэгэхгүй бол олон нийтэд тайлангаа хүргэх гэхээр 2015 онд 2013 оны тайлан ярих гээд байдаг. Хоёрдугаарт, Үндэсний зөвлөлийн хуралдаанаа бид заавал ажил ихтэй Ерөнхий сайдаа хүлээлгүйгээр оролцох боломжтой хүмүүсээ оролцуулаад улиралд 1 удаа хуралдвал яасан юм бэ? Үндэсний зөвлөлийн гишүүн миний хувьд оролцох боломж маш бага байна, жилд нэг удаа хуралддаг, их олон асуудал хэлэлцэх болдог ийм байна. Тэрийг анхаараачээ гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Дэлгэрмаа: Сүүлчийн саналд хариулт өгье. Шинэ Засгийн газар байгуулагдсан, 2014 онд бид Үндэсний зөвлөлийн хурлаа хийх ёстой байсан, Гэхдээ шинэ Засгийн газрын хувьд Үндэсний зөвлөлийн хуралдааныг 2014 онд зохион байгуулах үнэхээр тийм боломж байхгүй байлаа. Гэхдээ бид 2013 оны тайлангаа яаралтай батлах, 2015 оны төлөвлөгөөгөө батлах гээд чухал чухал асуудлууд хэлэлцэх шаардлагатай байсан тул төсвийн тодотгол хэлэлцэж буй төр засгийн ид ачаалалтай энэ цаг үед, та бүхний ажил ихтэй энэ цаг үед хурлаа зохион байгуулж байгаад хүлцэл өчье. Үнэхээр улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа. Тэр утгаараа бид Үндэсний зөвлөлийн хуралдааныг яаралтай товлож, 14 хоногийн та бүхэнд мэдэгдэж, Ерөнхий сайдаас тусгайлан цаг авч уг нь зохицуулсан байсан юм. Гэтэл төрийн ажил зогсохгүй байх ёстой гэдэг утгаараа сайдад янз бүрийн ажлууд гараад байдаг юм байна. 2015 онд Үндэсний зөвлөл нилээд эрч хүчтэй ажиллах шаардлага байгаа. Өнөөдөр би жишээлбэл АСЕМ-ийн гишүүн 53 орны төрийн тэргүүнүүдийг 2016 онд хүлээн авах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн анхны хуралдаанд оролцож байхад гадаад оронд бид улс орноо зөвөөр ойлгуулах, ялангуяа эдийн засгийн гол хүчин зүйл болсон уул уурхайн бодлогоо зөв зүйтэй ойлгуулах асуудлууд яригдаж байна, түрүүнд Баярцогт сайд ч бас нээлтийн үгээрээ хэлсэн, бид улсынхаа нэр хүндийг бодож цаашид маш эх оронч сэтгэлтэйгээр харилцан ойлголцож, хамтран ажиллах нэн шаардлагатай байна. Өнөөдрийн энэ хуралдаанаараа бид компаниудыгаа дэмжиж, ард иргэддээ нээлттэй тунгалаг байж, төр нь төр шиг байхгүй бол 2015 онд бидэнд, энэ Засагт ч угаасаа маш бага хугацаа байгаа. Тийм учраас бид эрч хүчтэй ажиллахын тулд ингэж олноороо олон цаг хуралдахын оронд ажил хэрэгч цөөхөн хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүдээрээ шуурхай асуудлыг хэлэлцэж, цахимаар хоорондоо харилцаж, шийдвэр, зөвлөмжөө гаргаад, харин гаргасан шийдвэр, зөвлөмжөө амьдрал дээр хэрэгжүүлэхийн төлөө ажиллалбал илүү цаг хугацаа хэмнэнэ, илүү зохимжтой болов уу. Тэгэхээр Эрдэнэжаргалын гаргасан саналыг харгалзая, Ажлын албанаас аль болох зохион байгуулах талаар анхааръя. Баярлалаа. За 2015 оны төлөвлөгөөтэй холбоотой асуулт, саналаа нэгтгэе. Би хуралдаанаа дахиад 20 минут сунгалаа.

Н.Алгаа: 2015 оны төлөвлөгөөтэй холбоотой саналаа хэлээд чөлөө аваад явж болох уу?

Б.Дэлгэрмаа: Үгүй ээ, одоо би дахиж чөлөө өгөхгүй, яг энэ байгаа бүрэлдэхүүнээрээ асуудлаа хэлэлцээд хурлаа өндөрлөө. Одоо саналаа та бүхэн 2014 оны төлөвлөгөөний биелэлттэй холбоотой санал, шүүмж, асуулт, 2015 оны төлөвлөгөөг тараасан учраас би танилцуулга хийхгүйгээр гишүүд төлөвлөгөөтэй холбоотой нэмэх, хасах саналуудаа нэгтгээд хэлээрэй. 2, 3 дугаар асуудлыг нэгтгэлээ.

Н.Алгаа: 2015 оны төлөвлөгөө хэрэгжинэ гэдэгт би хувьдаа итгэлтэй байна. Гэхдээ 2 зүйл дээр анхаармаар байна. Нэг нь сурталчилгааны асуудал. Мэдээллийг зорилтот бүлгүүдэд хүргэх формат хэрэгтэй байна. Төр, компани, иргэний нийгэм гэсэн зорилтот бүлгүүддээ зориулж мэдээллийг хялбар ойлгогдох, уншигдахаар боловсруулахгүй бол зузаан тайлан, цаасанд дарагдаад байна. Энэ дээр нилээд том өөрчлөлт хийх хэрэгтэй байна гэсэн саналтай байна. Хоёрдугаарт түрүүний Эрдэнэжаргалын хэлсэнчлэн Үндэсний зөвлөлийн хуралдааныг тогтмолжуулах шаардлагатай байна. Гэхдээ заавал ажлын төлөвлөгөөнд тэдэн удаа хуралдах гэж оруулах нь хаашаа юм, зүгээр түрүүнд та хэлсэн цомхон ажлын хэсгийг байгуулж, тэр ажлын хэсгээрээ асуудлуудаа шийдвэрлээд, шийдвэрлэх боломжгүйг нь Үндэсний зөвлөлийн хурлыг хуралдуулж шийдвэрлүүлээд явахад болохгүй юм байхгүй гэж бодож байна.

Б.Бямбадагва: 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээг ажлын албаны цахим хуудсанд байршуулна гэсэн байна. Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн Ашигт малтмалын газрын вэбсайтад сар бүр олон нийтэд ил тод болж байна, хүсвэл кадастрын цахим систем рүү орж дэлгэрэнгүй мэдээлэл авч байна. Ийм байхад заавал ажлын албаны цахим хуудсанд давхар давхар байршуулах шаардлага байгаа юу? Хоёрдугаарт, төлөвлөгөөний 3 дугаарт хайгуулын ажлын мэдээ гэж байна, энэ нь хувийн компаниудын хайгуулын ажлын мэдээ юу? Тухайлбал, ийм өрөмдлөг хийж, ийм хэмжээний нөөц тогтоосон, ийм зардал гаргасан гэх зэрэг тухайн компанийн нууцтай холбоотой мэдээллийг ил тод болгох шаардлага байна уу, үгүй юу? Тэгэхээр энэ 2 ажлыг төлөвлөгөөнөөс хасах саналтай байна. Ашигт малтмалын газар үндсэн хийдэг ажилаа хийе, маш олон мэдээ тайлан хүлээн авч байгаа, мэдээллийг боловсруулахын тулд бид 10 ажилтныг үндсэн ажлаас нь чөлөөлж байж тэр мэдээллийг гаргаж байна, мэдээллийг боловсруулж аудитын байгууллагад гаргаж өгч байгаа, сургалт, арга хэмжээнд оролцож байгаа, хөдөө орон нутгийн томилолтод хамрагдаж байгаа, тусгай зөвшөөрөл, уулын ажлын төлөвлөгөө, тайлан гэх зэрэг мэдээллийг гаргаж өгч байгаа гэх мэт бид бол маш их ажил хийж байгаа. Тийм учраас энэ нэмэлт 2 ажлыг дэмжихгүй байна.

С.Бүрэнтогтох: Та бүхний энэ оройн амгаланг айлтгая. 2014 онд манай алтны салбарын компаниуд ОҮИТБС-ыг дэмжиж нилээд олон ажлыг хамтарч зохион байгуулсан. Энэ хүрээнд олж авсан туршлага, Ажлын хэсгийн гишүүний хувьд 2015 оны ажлын төлөвлөгөөнд саналаа хэлье. Мэдээллийг хүмүүст ойлгомжтой,

хүртээмжтэй байдлаар хүргэх асуудал яригдаж байна. Адам Смит Интернэйшл байгууллагын цахим тайлангийн систем төслийн хүрээнд тухайлбал алтны салбартай холбоотой мэдээллийг боловсруулж, тусад нь портал ажиллуулах боломжтой гэж байна. Ингэснээр төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоо сайжирч, гадны хөрөнгө оруулагчид алтны салбартай холбоотой бодитой мэдээллийг цаг алдалгүй авах ийм боломж бүрдэж байна. Тэгэхээр энэ ажлыг цахим тайлангийн системийн 2-р үе шатанд хэрэгжүүлэхээр ажлын төлөвлөгөөнд тусгаж өгөөчээ, та бүхэн дэмжиж өгөөчээ гэж хүсэх байна. Нэгэнт компаниудын мэдээлэл цахим системд орчих учраас мэдээллийг төрөлжүүлэн боловсруулах боломжтой гэж харж байгаа. Компанийн тухай хуулиар хэдэн кг алт олборлосон, борлуулсан мэдээлэл нь нууц байдаг, гэтэл ОУИТБС-ын тайлангаар бүх юм ил тод болоод байгаа. Энэ асуудлыг яах вэ? Иймд Үндэсний зөвлөл нууц гэж үзсэн шийдвэр эсхүл ил тод бай гэсэн шийдвэрүүдийг эргэн харж уялдуулах, төрийн байгууллагын уялдаа холбоог хангах талаас нь ажиллах зохих шийдвэр гаргавал алтны салбарын мэдээлэл олон нийтэд шуурхай хүрэх боломж байна гэж харж байна.

Б.Дэлгэрмаа: Мэргэжлийн хүмүүс алтыг салгаад тэгж оруулж болно гэж байн Уул уурхайн яам зөвшөөрч байна. Тэгэхээр төлөвлөгөөнд тусгаж болох юм байна.

Ч.Отгочулуу: Надад 2 асуулт байна. Ялангуяа ажлын албанаас асуумаар бай Канадын Гадаад хэргийн сайд өнгөрсөн оны 7 сарын сүүлчээр айлчилсан. Түүн дагаад Канадын их сургуулийн эрдэмтэн, оюутнууд ирсэн байсан. Тэгээд тэд ма ОУИТБС-ын хэрэгжилтэнд судалгаа хийж, ялангуяа манай тайланг их зузаан байн: 3 хуудсанд брошур болгож хийсэн байсан. Тэр юу болсон бэ? тэр Монгол хэл орчуулагдсан уу? Хоёрдугаарт, ТАН эвслээс нэвтрүүлэг хийгээд байсан, надаас сурвалжлага авч байсан, тэр юу болсон бэ? За дараа нь Норвегийн дарга нар бид хэтэрхий их мэдээлэл тайландаа оруулаад байна аа гээд байгаа юм. Тайланг захын 10 жилийн боловсролтой хүн, хөдөөгийн малчин иргэн ашиглахад ойлгог байдлаар боловсруулах ёстой гээд байгаа юм. Энэ санаачилгыг Уул уурхай дэмжээд байгаа цаад мөн чанар нь энэ уул уурхайн салбар чинь эдийн заса чухал хувь нэмэртэй юм шүү гэдгийг ард нийтэд энгийнээр ойлгуулахад оршоод юм. Энэ том тайлан чинь л хүмүүсийг айлгаад байгаа юм, бид байнга энэ тай хялбаршуулж, хүмүүст ойлгомжтой болго гэж санал тавьж байгаа. Тэр ажлын яг байна аа?

Ш.Цолмон: 2012 оны тайланг бид хүмүүст энгийн ойлгомжтой хүргэх зс нилээд олон контент, агуулга, брошур, материал боловсруулж, олон нийтэд т Тухайлбал инфографик бүхий ханын постер, брошур хийсэн, сум сумаар нь нс өдөрлөг зохион байгуулж буй сумын иргэдэд тарааж байна, цахим хуудсаг ойлгомжтой байдлаар сайжруулан шинэчилсэн, олон нийтийн сүлжээгээр сурталчилахаар фэйсбүүк, твиттер гэх мэт хаягуудыг нээсэн, сар бүр хүмүү сонин явуулж байна гэх мэт олон ажил хийж байгаа. Энэ ажлаа үргэлжлүүл онд илүү идэвх, санаачилгатай ажиллахаар төлөвлөж байна.

Б.Дэлгэрмаа: Форматын асуудал дээр түрүүнд Алгаа гуай ч бас санал хэлсэн. Транспарэнси интернэйшл байгууллагын төлөөлөл манай хуралдаанд сууж байна. Тэгэхээр бидний ажлыг олон нийтэд сурталчилах тал дээр туслах байх гэж найдаж байна. За өөр санал байна уу?

Н.Баярсайхан: Төсөв, санхүүгийн хязгаарлагдмал байдалтай байсан ч гэсэн 2014 онд тодорхой ажлууд зохион байгуулж, хэрэгжүүлсэн байсан. Тухайлбал тэр Үндэсний тайлангаас сумын түвшинд тайлан бэлтгэж, сумын иргэдэд тараасан чухал ажил болсныг цохон тэмдэглэмээр байна. Дэлхийн банкны санхүүжилт зогссон ч гэсэн Гансүх гэсэн хувь хүнээс шалтгаалахгүйгээр илүү хүчин чармайлт гаргасан бол санхүүжилт саатахгүй, зарим ажлууд хийгдэх боломжтой байсан гэж харж байгаа. Тэгэхээр санхүүжилтээс үл хамаарч үйл ажиллагаагаа тасалдахгүй явуулах талаас нь 2015 онд анхаарах хэрэгтэй. Түрүүнд Бямбадагва дарга ажлын төлөвлөгөөний 1, 3 дугаар ажлыг хасах гэж санал гаргаж байсан. Үүнийг хасах биш харин ч уялдуулах хэрэгтэй л дээ. 10 гаруй хүнийг үндсэн ажлаас нь чөлөөлж байж мэдээллийг боловсруулж байна гэж байсан. Тэгвэл цаашид яаж шаардлагатай мэдээллийг цахим мэдээллийн системийг ашиглан хялбар, шуурхай боловсруулах вэ гэдэг талаас нь харж хасах биш харин ч тэр ОУИТБС-ын цахим тайлангийн системтэй, Ашигт малтмалын газрын тусгай зөвшөөрөл, кадастрын системийг уялдуулах санал, санаачилга гаргах хэрэгтэй байна. Миний хувьд тэр заалтуудыг хасахгүйгээр, найруулгын хувьд уялдуулах гээд оруулах нь зүйтэй юмуу гэж харж байна. Төлөвлөөний 27, 32-35 дугаар ажлууд нэг л утгатай харагдаад байна л даа. Үндэсний чуулган хийх юм байна, дараа нь бүсийн чуулгадыг хийх юм байна. Энэ ажлыг хийхэд их зардал гардаг, гэтэл үр дүн нь юу байсан юм бэ? Бид үйл ажиллагаагаа тоочоод байгаа болохоос үр дүнг хэмжиж ярихгүй байгаа. Тиймээс энэ ажлуудыг илүү үр дүнгээ харж зөвхөн уул уурхай бүхий говийн бүс юмуу баруун бүсийг хамруулаад, арга хэлбэрээ өөрчлөөд зохион байгуулах гэсэн саналтай байна. Үндэсний чуулганд бүх 21 аймгийг хамруулах нь чухал юмуу? Эсхүл уул уурхайтай аймгийг хамруулах нь чухал юмуу? Ийм учраас Алгаагийн хэлснээр зорилтот бүлэг рүүгээ анхаарах хэрэгтэй гэж хэлмээр байна. За дараа нь хандив, хөрөнгө оруулалт гэсэн сэдвээр олон талт хэлэлцүүлэг хийе гэсэн саналтай байна. За дараа нь сумдад зориулсан мэдээлэл боловсруулах нилээд сайн аргачлал, гарын авлагыг ажлын албаны Дэлгэрмаа гаргасан байгаа. Энэ аргачлалаа аймаг, сум руу явуулах гэж ажлын төлөвлөгөөний 38, 39-д орсон байна. Энэ бол нэг л ажил юм. Үүний оронд энэ аргачлалаараа аймаг, сумдын дэд зөвлөлд сургалт зохион байгуулая гэж оруулах саналтай байна. 2015 онд баталгаажуулалт хийгдэнэ. Үүнээс өмнө ТАН эвслийн олон талт хэлэлцүүлгээс өөрсөддөө дотоод үнэлгээ хийе гэсэн зөвлөмж гарсан. Үүнийг 2015 оны ажлын төлөвлөгөөнд оруулах саналтай байна.

Б.Дэлгэрмаа: За Баярсайхан гишүүн ээ таны цаг дууссан шүү.

Н.Баярсайхан: За. Үндэсний зөвлөл 2014 онд нэг ч удаа хуралдаагүй. Нэг хуралдахаараа тайлан яриал, урьд оны төлөвлөгөөний биелэлт, ирэх оны төлөвлөгөө ярьсаар байгаад дуусдаг. Иймд бодлогын чанартай асуудлуудыг хэлэлцэх

хуралдааныг 6 сард зохион байгуулахаар ажлын төлөвлөгөөнд оруулах саналтай байна.

Б.Дэлгэрмаа: За одоо 2 хүн саналаа хэлээд өнөөдрийн хуралдааныг өндөрлөнө.

Х.Лхамаа: Ажлын төлөвлөгөөний 2 дугаар бүлэгт тайланг орон нутагт сурталчилах гэсэн ажлыг аймаг, сумдын дэд зөвлөл, иргэний нийгмийн эвсэлтэй хамтарна гэсэн байна үүнийгээ компаиудыгаа оруулаад бүх талууд гэсэн нь илүү үр дүнтэй байх. Тал талд өөр өөр хүмүүс баахан арга хэмжээ зохион байгуулаад байвал сүүлдээ орон нутгийн иргэд ирэхээ ч болино, тиймээс орон нутагт тайланг сурталчилах ажлаа нэг мөр, далайцтай, бүх талууд хамтраад, ялангуяа компаниудтайгаа хамтраад зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналтай байна. За дараа нь тэр бүсийн чуулгадыг зохион байгуулах гэсэн байна. За 21 аймагаа байг гэхэд үүнийг уул уурхай бүхий бүс нутагт зохион байгуулах нь чухал хэрэгцээтэй гэж үзэж байна. Яагаад гэвэл тэр болгон Үндэсний чуулганд холын аймгийн малчин иргэд оролцох боломжгүй, Үндэсний чуулганаар том бодлогын асуудал ярина, бүсийн чуулгадаар сумын, аймгийн гээд орон нутгийн асуудлаа ярина гэж бодож байна. Тийм учраас аймгийн дарга нараас гадна сумдын иргэдийг оролцуулбал энэ бол зөв, байж байх ёстой гэж бодож байна.

Б.Оюун: Газрын тосны газрын Оюун байна. Түрүүнд Ашигт малтмалын газрын Бямбадагватай санал нэг байна. Ажлын төлөвлөгөөний 1, 3 дугаар ажлыг хасах саналтай байна. Газрын тосны компаниуд цөөхөн, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 15, 16 компаниуд байгаа. 2014 онд тийм шилжилт хөдөлгөөн хийгдээгүй учраас манайхыг тэр 1 гэсэн хэсгээс хасмаар байна. За тэр хайгуулын ажлын тухайд Газрын тосны хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор, мөн эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор газрын тосны компаниуд бараг хайгуул хийгээгүй. Тиймээс бас л тэр 3 дугаар ажлаас манай агентлагийг хасах саналтай байна.

Б.Дэлгэрмаа: За саналуудыг сонсож дууслаа. Зохих засваруудыг хийж тэмдэглэлийг энэ Баасан гаригт гишүүдэд хүргүүлье. Та бүхэн эргээд саналаа өгөөрэй. 2015 оны төлөвлөгөөг зарчмын хувьд батлая. За батлах саналтай гишүүд гараа өргөө. За 2 дугаар асуудлын хүрээнд 2014 оны төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж үзэж байгаа гишүүд гараа өргөнө үү. За баярлалаа. Үндэсний зөвлөлийн 2014 оны “та бүгд энэ хурлыг 2014 оны хурал гэж ойлгоорой” хуралдаан өндөрлөлөө. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргын хувьд та бүгдэд бас нэг зүйл хэлмээр байна. 2015 онд Үндэсний зөвлөл арай өөрөөр ажиллана. Ингэж олон цагаар хуралдахгүй. Яагаад гэвэл монгол руу гадаадаас ажил хөөцөлдөх гээд утасдахаар бүх хүмүүс “хуралтай байна” гэж шивнэдэг. Цахим шуудан явуулдаг, хариу өгдөггүй. Бүгд хуралтай байгаад байдаг. Тэгэхээр бидний маш үнэтэй цаг хуралд ингэж зарцуулмааргүй байна. Тиймээс бид илүү прагматик, илүү ажил хэрэгч, гаргасан шийдвэр нь амьдрал дээр илүү хэрэгждэг ийм байдлаар Үндэсний зөвлөл ажиллана гэдгийг та бүгдэд амлаж байна. Цаг заваа гаргаж өнөөдрийн хуралдаандаа оролцсон Үндэсний зөвлөлийн гишүүддээ баярлалаа. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2014 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж үзэв.
2. Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2015 оны ажлын төлөвлөгөөг гишүүдийн гаргасан саналыг харгалзан тусгаж батлав.
3. 2014 оны төлөвлөгөөний биелэлт, 2015 оны төлөвлөгөөг ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт 1 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлэхийг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.
4. Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайланд 300-аас доошгүй компанийг хамрагдуулж, нэгтгэгчийн ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж, үр дүнг 2015 оны 2 дугаар улиралд багтаан Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд үүрэг болгов.
5. Нэгтгэлийн тайланг хийж гүйцэтгэх аудитын консерцумыг 2 жилээр сонгон шалгаруулах боломжтой эсэхийг судлан хариуг Үндэсний зөвлөлийн гишүүдэд 3 дугаар сард багтаан мэдээлэхийг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.
6. Үндэсний тайланг зорилтот бүлгүүдэд хүргэх мэдээллийг төрөлжүүлэн боловсруулж Ажлын хэсгийн 2015 оны эхний хуралдаанд танилцуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д үүрэг болгов.
7. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын мэдээллийн төвийг Төв, Дорноговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгуудад байгуулж, үр дүнг 2015 оны 3 дугаар улиралд багтаан Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд үүрэг болгов.
8. Төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч (Б.Дэлгэрмаа)-д даалгав.

Хуралдаан 18 цаг 50 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Дэлгэрмаа

Хурлын тэмдэглэлийг хянасан:

ОУИТБС-ын Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн арван
хоёрдугаар хуралдааны шийдвэр /2015-01-13/**

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол улсын ОУИТБС-ын 2013 оны буюу наймдугаар тайлан

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Их Британийн Харт Нойрс лтд, Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан аудитын консерцумын боловсруулсан Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2013 оны буюу наймдугаар нэгтгэл тайланг дэмжиж батлав.

2. Энэхүү тайланг олон нийтэд хүргэх, зорилтот бүлгүүдэд сурталчилах хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулахаар тогтов. Үүнд:

2.1 Тайланг ОУИТБС-ын Олон улсын удирдах хороонд 2015 оны 1 дүгээр сарын 20-ны дотор илгээхийг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

2.2 Тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар нийтэд мэдээлэх хэвлэлийн бага хурлыг 1 дүгээр сард багтаан зохион байгуулахыг ОУИТБС-ын ажлын алба, Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.

2.3 Тайланг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд чуулган завсарлахаас өмнө танилцуулахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх (Б.Дэлгэрмаа), Уул уурхайн яам (Р.Жигжид)-д даалгав.

2.4 Эх тайлан болон тайлангийн хураангуй хувилбарыг оролцогч талуудын болон ОУИТБС-ын ажлын албаны цахим хуудсанд байрлуулж, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.

2.5 Тайлангаас олж илрүүлсэн зүйлс, онцлох мэдээлэлтэй холбоотойгоор талуудын байр суурийг илэрхийлэх хэвлэлийн бага хурлыг 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Нээлттэй нийгэм форум (П.Эрдэнэжаргал)-д, Монголын Үндэсний уул уурхайн ассоциацийн ерөнхийлөгч (Н.Алгаа)-д, салбарын үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлэх зорилго бүхий “Ил тод уул уурхай” сэтгүүлчидтэй уулзах уулзалтын үеэр ОУИТБС-ын талаар мэдээлж ажиллахыг Уул уурхайн яам (Р.Жигжид)-д, даалгав.

2.6 Тайлангаас зорилтот бүлгүүдэд зориулсан мэдээлэл боловсруулж, 2015 оны ажлын төлөвлөгөөнд заасны дагуу тогтмол сурталчилахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

3. Уул уурхайн салбарын орлогыг тусад нь бүртгэх асуудлаар, байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа төлбөр, мониторинг хийх асуудлаар, аудитын

нэгтгэлийн үеэр аудитын байгууллагад гаргаж өгөх шаардлагатай мэдээллийн жагсаалт боловсруулж, түүнийг нэг стандарт, маягтад оруулах асуудлаар, эрдэс баялгийн салбарт байгуулагдсан гэрээ, түүний ач холбогдлыг судлах асуудлаар, уул уурхайн салбарын эхний топ 10 аж ахуйн нэгжүүдэд хууль жигд үйлчлэх асуудлаар тус тус төрөлжсөн 5 ажлыг хэсгийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүд, холбогдох төрийн байгууллагуудыг оролцуулан 1 дүгээр улиралд багтаан байгуулах, ажлын удирдамж боловсруулж, чиглэл өгч ажиллахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх (Б.Дэлгэрмаа)-д даалгав.

4. Тайлангаар дунд болон муу үнэлгээ авсан төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдээс тайлбар авч, удирдах дээд байгууллагад хариуцлага тооцох тухай албан тоот илгээх, зохих сургалт зохион байгуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд үүрэг болгов.

5. Жил бүр Засгийн газрын гаргадаг ОУИТБС-ын тайланг Үндэсний аудитын газраар баталгаажуулах, шаардлагатай тул холбогдох журам боловсруулж, мөрдүүлэхийг Сангийн яам (Ж.Эрдэнэбат), Үндэсний аудитын газар (А.Зангад)-т зөвлөмж болгов.

6. Нэгтгэлийн тайлангаар ил тод болсон олборлох үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигчийн мэдээллийг нэгдсэн сан болгож, цахим хуудастаа байрлуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав

II, III ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2014 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2015 оны төлөвлөгөөний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2014 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангалттай гэж үзэв.

2. Монгол Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2015 оны ажлын төлөвлөгөөг гишүүдийн гаргасан саналыг харгалзан тусгаж батлав.

3. 2014 оны төлөвлөгөөний биелэлт, 2015 оны төлөвлөгөөг ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт 1 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлэхийг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

4. Монголын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайланд 300-аас доошгүй компанийг хамрагдуулж, нэгтгэгчийн ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж, үр дүнг 2015 оны 2 дугаар улиралд багтаан Ажлын хэсэгт танилцуулахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд үүрэг болгов.